

---

## АГУУЛГА

### Нэгдүгээр бүлэг. Компанийн тухай

2-5

- 1.1. Компанийн танилцуулга
  - 1.2. Компанийн бүтэц, зохион байгуулалт
- ### Хоёрдугаар бүлэг. Компанийн засаглал

6-8

- 2.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал
  - 2.2. Төлөөлөн удирдах зөвлөл
  - 2.3. Гүйцэтгэх удирдлагын талаар
- ### Гуравдугаар бүлэг. Үндсэн үйл ажиллагаа

9-18

- 3.1. Уул уурхайн талаар
  - 3.2. Борлуулалтын талаар
  - 3.3. Машин техникийн ашиглалтын талаар
  - 3.4. Байгаль орчин, нөхөн сэргээлтийн талаар
  - 3.5. Дулаан үйлдвэрлэлийн талаар
  - 3.6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар
- ### Дөрөвдүгээр бүлэг. Санхүү, эдийн засгийн үзүүлэлт

18-22

- 4.1. Хөрөнгө оруулалтын талаар
- 4.2. 2020 оны санхүүгийн аудитлагдсан тайлан
- 4.3. Худалдан авалт
- 4.4. Хөрөнгө талаар

### Тавдугаар бүлэг. Нийгмийн хариуцлага, орон нутгийн хамтын ажиллагаа

22-23

- 5.1. Нийгмийн хариуцлага, орон нутгийн хамтын ажиллагаа
- ### Зургаадугаар бүлэг. Удирдлага, тогтоол шийдвэрийн биелэлт

23-25

- 6.1. Тогтоол, тушаал шийдвэрийн талаар
- 6.2. Хүний нөөц талаар

25-30

### Долоодугаар бүлэг. Шахмал түлшний үйлдвэр

---

## НЭГ. КОМПАНИЙН ТУХАЙ

### 1.1. Компанийн танилцуулга:

Тус уурхайн нь Орон нутгийн нүүрсний хэрэгцээг хангах зорилгоор МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын СНЗ-ийн 1961 оны 191/142 тоот тогтоолоор нүүрсний ордод нарийвчилсан судалгаа шинжилгээ хийж, уурхай байгуулах шийдвэр гарч бэлтгэл ажлыг ханган БНМАУ-ын Геологи, Уул уурхай, Үйлдвэрийн яамны харьяа “Баянтээг”-ийн уурхай жилдээ 25,0 мян/тн нүүрс гаргах хүчин чадалтайгаар байгуулагдан 1962 оны 8 дугаар сарын 28-нд нээлтээ хийснээс хойш 59 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна. 1970-аад оноос нүүрсний хэрэглээ өсөж үүнтэй холбоотойгоор уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор 1974 оноос нарийвчилсан хайгуул, судалгаа явуулж, үйлдвэрлэлийн ашиглалтын нөөцийг 29,6 сая/тн-оор тогтоож, 1980 онд Уулын өргөтгөлийн ажил хийгдсэнээр тус уурхай жилдээ 150,0 мян/тн нүүрс гаргах хүчин чадалтай болсон. Аймгийн өмч хувьчлалын комиссын 1994 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор Баянтээгийн уурхайг хувьчлах шийдвэр гарч Хувьцаат Компани болон зохион байгуулагдсан.

“Баянтээг” ХК-ийн нийт хувьцааны 70 хувийг орон нутаг, 24 хувийг “Шунхлай” групп, үлдэх хувийг иргэд эзэмшиж байна.

Компанийн гүйцэтгэх захирлаар Н.Данзан 2020 оны 08 дугаар сарын 03-наас томилогдон ажиллаж байна.

Компани нь Ашиглалтын тусгай зөвшөөрөл 367А лицензийн дагуу 581,74 га газар эзэмшдэгээс 59 жилийн хугацаанд 67,4 га талбайд олборлолт явуулж байна.

#### “Баянтээг” ХК-ийн алсын хараа:

Бид зах зээлд чанартай нүүрс борлуулах, тэргүүлэх үйл ажиллагаатай компани болно.

#### “Баянтээг” ХК-ийн эрхэм зорилго:

Уурхайчин бид орчин үеийн техник, технологийг мэргэшсэн боловсон хүчний ур чадвар, хүсэл тэмүүлэлтэй хослуулан эх орныхоо хөгжлийн, эдийн засгийн өсөлтөнд хувь нэмрээ оруулна.

#### Оноосон нэр

#### Үйл ажиллагааны чиглэл

#### Компанийн албан ёсны

#### хаяг

“Баянтээг” хувьцаат компани

Чулуун нүүрс олборлолт

Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын 2-р баг

Утас: 88295162, 88997784

И-мэйл: [bntg\\_mining@yahoo.com](mailto:bntg_mining@yahoo.com)


Фэйсбүүк: Баянтээг ХК page хуудас

## 1.2. Компанийн бүтэц, зохион байгуулалт:

“Баянтээг” ХК нь уулын хэсэг, захиргааны хэсэг, ШТҮйлдвэр гэсэн 3 хэсэг 70 ажиллагсадтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

“Баянтээг” ХК нь 2020 онд компанийн бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулсан нь компанийн засаглалыг сайжруулах, удирдлагын шат дамжлагыг багасгаж уялдаа холбоог сайжруулахад чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон.

“Баянтээг” ХК-ийн, зохион байгуулалт /схем/-ыг дор дурдсанаар үзүүлэв.





ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
“БАЯНТЭЭГ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 01

Баянтээг

▮ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ▮  
ХУРЛЫГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг тус тус үндэслэн “Баянтээг” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай асуудлаар хэлэлцэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааг тайлагнах хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Өвөрхангай аймгийн Арвайхээр суманд 2021 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 10 цагт Арвайхээр сумын “Нутгийн удирдлагын ордон”-нд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүдэхээр оруулсугай.
  - a. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж батлах
  - b. Компанийн 2020 оны Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцэж батлах
  - c. Компанийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж батлах
  - d. Компанийн 2021 оны Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэлэлцэж батлах
  - e. Компанийн ТУЗ-ийн болон Гүйцэтгэх удирдлагын 2021 оны цалин урамшуулал болон зардлын төсөн
  - f. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох
  - g. Аудитын байгууллагын тайлан дүгнэлт
  - h. Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
  - i. Бусад
3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2021 оны 03 дугаар сарын 09-ний өдрөөр тогтоосугай.
4. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Хавсралт №1-ийн дагуу баталж, мэдээг Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар болон өдөр тутмын сонингоор хурлын зар мэдээг мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэхийг хурал зохион байгуулах комисс-т даалгасугай.
5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг Хавсралт №2-р баталсугай.
6. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн тавилцаж болох бичиг баримтын жагсаалтыг Хавсралт №3-р баталсугай. Хавсралт №3-д заасан бичиг баримтыг ажлын өдрүүдэд 09<sup>00</sup>-17<sup>00</sup> цагийн хооронд “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн

тов оффис болон компанийн өөрийн байранд болон цахимаар ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Б.Март/-с авч танилцах эрхтэй болохыг дурьдсугай.

7. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээ хэлэлцэх асуудлаар санал авах саналын хуудасны загварыг Хавсралт №4-р баталсугай.

8. Хувьцаа эзэмшигчдээ “Санал авах хуудас”-ыг хүдгэн авах сүүлийн өдрийг харьяалагдах Үнэт цаасны компаниар нь дамжуулан хурал хуралдах өдрөөс ажлын 5-с доошгүй хоногийн өмнө байхаар тогтсугай.


9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын даргаар Гүйцэтгэх захирал Н.Данзан , гишүүдээр Ерөнхий инженер Л.Энх-Отгон, Ерөнхий санхүүч Ю.Ариунтунгалаг нарыг тус тус томилсугай.

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар Д.Нэмэхбаяр, тооллогын комиссын даргаар “Баянтээг” ХК –ний бичиг хэрэг, аж ахуйн нярав Л.Ган-Отгон, гишүүн “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн зөвлөх Б.Онон нарыг тус тус томилсугай.



 Д.НЭМЭХБАЯР

Төлөөлөл удирдах зөвлөлийн 2021 оны 02 дугаар сарын 15-  
ны өдрийн 01 дүгээр тогтоолын  
"Хавсралт №2"



**"БАЯНТЭЭГ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ**

1	Хурлын ирцийг бүртгэх (ажлын хэсэг)	10:00-10:30
2	Хурлын ирцийг мэдээлэх (ажлын хэсэг)	5 минут
3	Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах	5 минут
4	Хурлаар хэлэлцэх асуудлуудыг дарааллын дагуу танилцуулах	40 минут
5	Хувьцаа эзэмшигчид үг хэлэх, санал гаргах	20 минут
6	Санал хураалт	20 минут
7	Хурлын завсарлага	5 минут
8	Тооллогын комиссын дарга санал хураалтын дүнг танилцуулах	15 минут
9	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах	10 минут
10	Хурлыг хаах (хурлын дарга)	5 минут

## ХОЁР. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

### 2.1. Хувьцаа эзэмшигчдийн талаар:

Компанийн хувьцаа, эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг 2020 онд нийт 3 удаа зохион байгуулсан. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар компанийн 2019 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн дүгнэлтийг батлах, 2020 оны Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, ТУЗ болон Гүйцэтгэх захирлын зардлын төсвийн тухай, Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, Нүүрсний үнэ нэмэх тухай, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, Шахмал түлшний үйлдвэрийн бүтэц зохион байгуулалтанд өөрчлөлт оруулах тухай, гишүүдийг шинээр сонгох, хараат бус гишүүдийг сонгох асуудлуудыг тус тус хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн.

Компанийн хувьцааны 5 хувиас дээш багцын эзэмшигчид

№	Хувьцаа эзэмшигчид	Хувьцааны тоо	Эзлэх хувь
1	Өвөрхангай ОНӨмч	176825	70
2	Шунхлай групп ХХК	59452	23.5

### 2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн талаар:

2020 онд Төлөөлөн удирдах зөвлөлийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар шинэчлэн баталж шинэ бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулсан. Хуульд заасны дагуу ердийн гишүүн-6, хараат бус-3, нийт 9 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж ирлээ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороодын бүрэлдэхүүнийг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 04 дугаар сарын 03-ны өдрийн хурлаар шинэчлэн баталсан.

Компанийн засаглалыг сайжруулах ажлын хүрээнд, Төлөөлөн удирдах зөвлөл нь тайлант хугацаанд нийт 7 удаа хуралдаж, 23 тогтоол гарган шийдвэрийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

№	Огноо	Төлөөлөн удирдах зөвлөлийн Тогтоол
1	2020.01.15	ТУЗ-ийн нарийн бичиг томилох тухай.
2	2020.01.15	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай.
3	2020.03.11	Хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай.
4	2020.04.03	Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн тухай.
5	2020.04.03	ТУЗ-ийн дарга сонгож батлах тухай.
6	2020.04.03	ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгож батлах тухай.
7	2020.04.03	ТУЗ-ийн хороодыг байгуулж батлах тухай.
8	2020.04.03	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай.

9	2020.04.03	Гүйцэтгэх захиралын урамшуулал олгох тухай.
10	2020.04.03	2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах тухай.
11	2020.04.03	Ногдол ашиг хувиарлах тухай.
12	2020.04.20	Шахмал түлшний үйлдвэрийн зардал зарцуулах тухай.
13	2020.04.20	Тэтгэмж олгох тухай.
14	2020.04.20	Ногдол ашиг дахин хувиарлах тухай.
15	2020.04.20	Ажлын хэсэг байгуулах тухай.
16	2020.07.29	Гүйцэтгэх захирал О.Сумъяасүрэнг ажлаас чөлөөлж, гүйцэтгэх захиралаар Н.Данзанг томилох тухай
17	2020.09.03	Шахмал түлшний үйлдвэрийн талаар авах арга хэмжээний тухай.
18	2020.09.03	Гэрээ байгуулах, эрх олгох тухай.
19	2020.09.03	Нүүрс борлуулах тухай.
20	2020.09.03	Баянтээг багийн төвд шилэн кабель татах зардал батлах тухай.
21	2020.12.16	Нүүрсний үнэ нэмэх хугацааг хойшлуулах тухай.
22	2020.12.16	Нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлэх тухай.
23	2020.12.16	Өндөр настан, отрын малчдад дэмжлэг үзүүлэх тухай.

Зэрэг асуудлуудыг тухай бүрд нь хуралдан шуурхай шийдвэрлэн ажиллаж ирсэн байна.

“Баянтээг” ХК нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт 252 608 ширхэг энгийн хувьцаатай. Үүнээс 236 277 дээрх хувьцаа эзэмшигч эзэмшдэг бөгөөд үлдсэн 16 331 хувьцааг иргэд эзэмшиж байна. 2021 оны 03 дугаар сарын 17-ний өдрийн байдлаар 252 608 ширхэг энгийн хувьцааг 243 хувьцаа эзэмшигч эзэмшиж байна. Тус компанийн хувьцаа 30 үнэт цаасны компаниар тархаж үүнээс ТӨХ II, “Тулгат чандмань”, “Баян ҮЦК” ХХК-дад тус төвлөрсөн байна.



---

**2020 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР  
СОНГОГДСОН ТУЗ-ИЙН ГИШҮҮД**



**Д.Нэмэхбаяр**

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга



**Ю.Батсайхан**  
ТУЗ-ийн гишүүн



**М.Нинжбадгар**  
ТУЗ-ийн гишүүн



**Г.Баясгалан**  
ТУЗ-ийн гишүүн



**З.Дашзэвэг**  
ТУЗ-ийн хараат бус гишүүн



**Д.Миеэгомбо**  
ТУЗ-ийн гишүүн



**Б. Ичинноров**  
ТУЗ-ийн гишүүн



**Л.Жаргалбаатар**  
ТУЗ-ийн хараат бус гишүүн



**Ц.Оюун**  
ТУЗ-ийн хараат бус гишүүн

---

### 2.3. Гүйцэтгэх удирдлагын талаар:

“Баянтээг” ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу компанийн төсөв, хөрөнгийг зохих журмын дагуу үр ашигтай, хүртээмжтэй зарцуулах зарчмын дагуу үндсэн үйлдвэрлэл, уулын ажил, маркетинг борлуулалт, худалдан авалт, нийгмийн хариуцлагын төсөл хөтөлбөр, байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, “COVID-19” цар тахлын үеийн халдвар хамгаалалын дэглэмийг сайтар сахиж, компанийн засаглалыг сайжруулахад чиглэн үйл ажиллагаагаа зохион байгуулж өмнөө дэвшүүлсэн зорилго, зорилтоо амжилттай хэрэгжүүлэн ажиллаа.

Компанийн дүрэм бусад холбогдох хууль, журмын дагуу Хөдөлмөрийн дотоод журам, Хамтын гэрээ, ажилтан албан хаагчдын мөрдөх Ёс зүйн дүрэм, зэргийг шинэчлэн, шинээр боловсруулж нийт ажилчдаар хэлэлцүүлэн гүйцэтгэх захиралын тушаалаар батлан мөрдөн ажиллаж байна. Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм, төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан эрх үүргийн дагуу компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ирлээ. Үүнд:

- Үндсэн үйлдвэрлэл, хөрс хуулалт, нүүрс олборлолтын үйл ажиллагаанд өдөр бүр хяналт тавьж, ажилтан бүрийг үүрэг даалгавраар ханган хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн журмыг чанд мөрдүүлж, ямар нэгэн аваар осолгүй ажиллаа.
- Шахмал түлшний үйлдвэрийн үйл ажиллагааг удирдлагаар ханган тоног төхөөрөмжүүдийг горимд оруулах, кокс гаргах, шахмал түлшний барьцалдуулагч хийж, туршилтын 100 тн шахмал түлш үйлдвэрлэн ажилласан. Мөн ажлын байрны эрсдэлийн үнэлгээг хийж, тоног төхөөрөмжүүдийг паспортжуулсан
- Нийгмийн хариуцлагын хүрээнд төлөвлөсөн ажлуудыг зохих хууль журмын дагуу хийж гүйцэтгэн, аймгийн хэмжээнд ган болж зудын нөхцөл байдалд шилжсэнтэй холбогдуулан “Баянтээг” багийн малчин өрхүүдэд тээврийн зардалгүй 20.000 орчим тн өвс нийлүүлэн нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэн ажиллаа.

Харилцаа холбооны байгууллагуудад удаа дараа хүсэлт хүргүүлсний эцэст “Skynetworks” Компанийн 200 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар, Төлөөлөн удирдах зөвлөлд санал оруулж шийдвэрлүүлснээр компанийн 54,6 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, нийт 254,6 сая төгрөгийн санхүүжилтээр Сэнжитийн хоолойгоос 22 км шилэн кабель татан интернетэд холбон харилцаа холбооны асуудлыг хямд зардлаар бүрэн шийдвэрлэж ажиллаа. Шилэн кабельд холбосноор багийн хэмжээнд “UNITEL”, “SKYTEL” үүрэн телефонын оператор компануудын 4G сүлжээ орж, компани төдийгүй төрийн байгууллагууд, банкууд бусад байгууллага, иргэд, аж ахуйн нэгжүүдийн ажиллах нөхцөл эрс сайжирсан чухал ач холбогдолтой ажил болоод байна.

## ГУРАВ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 3.1. Уул уурхайн талаар:


Баянтээгийн уурхай 2020 онд 597.5 мян/м<sup>3</sup> хөрс хуулж, 200.0 мян/тн нүүрс олборлон борлуулах төлөвлөгөөтэй ажилласан. Хөрс хуулалтанд ЭКГ-5А экскаватор-1ш, HYUNDAI R850LC-9 экскаватор -1ш, HYUNDAI R520LC-9S экскаватор -1ш, CAMC HM-390 автосамосвал-2ш, NORTH BENZ автосамосвал-4ш, HOWO-60 автосамосвал-2ш, D65E бульдозер-1ш, SD-300N автоачигч-1ш, Liugong 4180 маркийн автогрейдер зэрэг техникүүдээр 1 ээлжээр ажиллах, хөрс хуулалтыг 40-36, 47-51-р хайгуулын шугам хооронд нийт 822.7 мян/м<sup>3</sup> хөрс хуулж, хөрс хуулалтын төлөвлөгөөг 137,7%-иар давуулан ажиллаа.

### 2020 оны хөрс хуулалт, нүүрс олборлолт, борлуулалтын гүйцэтгэл


Хүснэгт №1

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь
1	Нүүрс олборлолт	мян.тн	200.0	221.9	111.0%
2	Хөрс хуулалт	мян.м <sup>3</sup>	597.5	822.7	137.7%
3	Нүүрс борлуулалт	мян.төг	5,800,000.0	6,435,100.0	111.0%
4	Уулын цул	мян.м <sup>3</sup>	857.5	1111.2	129.6%
5	Х.Х.Коэффициент	м <sup>3</sup> /тн	2.9	3.7	127.5%

# 1. 2020 оны уулын ажлын 3D модель зураг



## 2. Ухаж ачих ажлын паспорт



## 3. 2020 оны нүүрс олборлолтын гүйцэтгэлийн талбайн дэвсгэр зураг

/Зүүн карьер/

1В блокоос 2020 онд олборлосон нүүрс 41,3мян.м3

1А блокоос 2020 онд олборлосон нүүрс 10,3мян.м3







## 2020 онд борлуулсан нүүрсний чанарын үзүүлэлт



Bureau Veritas Inspection and Testing Mongolia LLC  
 Ulaanbaatar Laboratory  
 Engyels Street 36,  
 Khovoo 1, Bayengol District,  
 ULAANBAATAR, Mongolia  
 Phone: + 976 75952580 Fax: + 976 75952561

**BV Reference # :** BVMN2595  
**Date Received:** 31-August-2020  
**Date Reported:** 04-September-2020

**ORIGIN :** Bayanteg JSC.,

**DESCRIPTION :** Coal sample

**REPORTED TO :** Mr Enkh-Otgon.L.

Sample Identification			Proximate Analysis										General Analysis						
BV Job Number	BV Codes	Client Codes	Total Moisture % (wt)	Analysis Sample Moisture % (ad)	Ash % (ar)	Ash % (ad)	Ash % (db)	VM % (ar)	VM % (ad)	VM % (db)	VM % (daf)	FC % (ar)	FC % (db)	GCV MJ/kg (ar)	GCV MJ/kg (ad) Not Corrected for Sulfur	GCV MJ/kg (db) Corrected for Sulfur	GCV MJ/kg (db)	GCV kcal/kg (ad)	GCV kcal/kg (db)
BV Ажлын дугаар	BV Дээжний дугаар	Эзхиалэгчийн дээжний дугаар	Нийт чийг	Шенжилгээний дээжний чийг	Үнс (Хүлээн зогсон төлөг)	Үнс (Агаарт хатаасан төлөг)	Үнс (Хуурай төлөг)	Дэгдэм хий бодис (Хүчилж ялсан тоолоо)	Дэгдэм хий бодис (Агаарт хатаасан тоолоо)	Дэгдэм хий бодис (Хуурай төлөг)	Дэгдэм хий бодис (Хуурай үнсгүй төлөг)	Нүүрсгэр өгч (Агаарт хатаасан төлөг)	Нүүрсгэр өгч (Хуурай төлөг)	Илчлэг чанар (Хүлээн зогсон төлөг)	Илчлэг чанар (Агаарт хатаасан S-дусаргүй төлөг)	Илчлэг чанар (Агаарт хатаасан S-дусартай төлөг)	Илчлэг чанар (Хуурай төлөг)	Илчлэг чанар (Агаарт хатаасан төлөг)	Илчлэг чанар (Хуурай төлөг)
BVMN2595	M22256	KhSh_30	4.8	4.2	8.9	9.0	9.4	39.8	40.0	41.8	48.1	48.8	48.9	26.07	26.23	26.13	27.38	6241	6515
BVMN2595	M22267	KhSh_51	5.7	4.7	15.0	15.2	15.9	40.4	40.8	42.8	50.9	39.3	41.2	29.07	28.98	28.26	29.76	6755	7088


Reported by: Oyuntuya Enkhoe   
 Reporting Officer





**Bureau Veritas**  
 Reporting Officer  
 E.Oyuntuya

Dated 04 September-2020

“Баянтээг” ХК-ийн үйл ажиллагааны хамгийн том хүчин зүйл болох хөрс хуулалт, нүүрс олборлолт болон түүнтэй уялдан гарах томоохон зардлын нэг дизель түлшний зарцуулалтыг доорхи хүснэгтэнд харуулав.



### 2020 онд тээвэрлэсэн хөрсний үзүүлэлт техникийн төрлөөр






### 3.2. Борлуулалтын талаар:


“Баянтээг” ХК нь 2020 оны нүүрс олборлолтыг 44-42, 53-50-р хайгуулын шугамын хооронд нийт 221.9 мян.тн нүүрс олборлон борлуулж нүүрс борлуулалтын төлөвлөгөөг 111.0%-иар давуулан биелүүлсэн. Дараа онд шилжих нөөц 64.7 мян.тн байна.

Тус компани 2019 онд нийт 210.6 мян.тн нүүрс борлуулж, 6,1 тэр.бум төгрөгийн борлуулалтын орлого төвлөрүүлж байсан бол 2020 онд 221.9 мян.тн нүүрс борлуулж 6,4 тэр.бум төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Он тус бүрээр харьцуулсан үзүүлэлтийг графикаар үзүүлбэл



2020 ийг Өвөрхангай, Баянхонгор, Архангай, Булган, Дархан, Улаанбаатар, Говь-Алтай, Хөвсгөл, Төв, Эрдэнэт, Завхан, Ховд, Дундговь аймгуудийн агаарын бохирдлын үнэмлэхүй хэмжээг 221.9 үү/дм<sup>3</sup> олборлон ажиглав.



### 2020 Борлуулалт аймгуудаар

1. Өвөрхангай	94326.83
2. Баянхонгор	33446
3. Архангай	27431
4. Орхон	19053.65
5. Булган	13532.05
6. Дархан	8954.1
7. Говь-Алтай	7944.47
8. Төв	5828.4
9. Хөвсгөл	4440.25
10. Улаанбаатар	3190.25
11. Завхан	2406.4
12. Сэлэнгэ	1085.9
13. Дундговь	285.35

**НИЙТ ДҮН: 221924.90**

### 3.3. Машин техникийн ашиглалтын талаар:



Улсын дугаар	6039 өөр
Марк	NORTHBENZ
Үйлдвэрлэсэн улс	Хятад
Үйлдвэрлэсэн он	2012
Ашиглалтанд орсон он	2012
Зориулалт	Өөрөө буулгач

Он сар	Оны эхний мот/цаг	Ажилсан мот/цаг	Түлш /л	1мот/цаг зарцуулсан	салбаг мян/төг	Тос тосолгоо мян/төг	Их засвар	Дугуй /ш	Техник эзэмшигч
2013									А.Амарсайхан
2014	2843	571	5830	10.2	490000				Б.Гантөмөр
2015	3414	1036	10570	10.2	7090000			10-ш	Б.Гантөмөр
2016	4450	1334	13615	10.2	1047222	801817		0	Б.Гантөмөр
2017	5784	857	8750	10.2	3459285	795824	Ээлж,1	0	Б.Гантөмөр
2018	6641	897	9420	10.2	8886951	632970.5		8ш	Б.Гантөмөр
2019	7538	797	8145	10.2	1444042.5	828836	Мотор ээлж,1	10ш	Б.Гантөмөр
2020	8335	1306	16215	12.4	7891597		Ээлж,1	1ш	Б.Гантөмөр



Улсын дугаар	6039 өөр
Марк	NORTHBENZ
Үйлдвэрлэсэн улс	Хятад
Үйлдвэрлэсэн он	2012
Ашиглалтанд орсон он	2012
Зориулалт	Өөрөө буулгач

Он сар	Оны эхний мот/цаг	Ажилсан мот/цаг	Зарцуулсан Түлш /л	1мот/цаг зарцуулсан	салбаг мян/төг	Тос тосолгоо мян/төг	Их засвар	Дугуй /ш	Техник эзэмшигч
2017	0	1185	11456	9.6	42615	184064		ө-11-ш	О.Жавхлантагс
2018	1185	1403	10987	7.9	3704780	346120		4-ш	О.Жавхлантагс
2019	2588	1451	14568	10.1	4767872	386496		6-ш	О.Жавхлантагс
2020	4039	1576	20340	12.9	4780356			2-ш	О.Жавхлантагс
2021	5615							0	О.Жавхлантагс



Улсын дугаар	5106 өвө
Марк	NORTHBENZ
Үйлдвэрлэсэн улс	Хятад
Үйлдвэрлэсэн он	2016
Ашиглалтанд орсон он	2017
Зориулалт	Өөрөө буулгач

Он сар	Оны эхний мот/цаг	Ажилсан мот/цаг	Зарцуулсан Түлш /л	1мот/цаг зарцуулсан	салбаг мян/төг	Тос тосолгоо мян/төг	Их засвар	Дугуй /ш	Техник эзэмшигч
2017	214	1027	11456	11	42615	184064	0	ө-11ш	А.Лүрээсүрэн
2018	1238	1441	11075	7.7	2428589	397437	0	2-ш	А.Лүрээсүрэн
2019	2679	1328	13868	10.5	6540272	422441	0	8-ш	А.Лүрээсүрэн
2020	4007	1653	21451	13	3397703		0	1-ш	А.Лүрээсүрэн
2021	5660							0	А.Лүрээсүрэн



Улсын дугаар	
Марк	SAMC
Үйлдвэрлэсэн улс	хятад
Үйлдвэрлэсэн он	2019
Ашиглалтанд орсон он	2019
Зориулалт	Өөрөө буулгач

Он сар	Оны эхний мот/цаг	Ажилсан мот/цаг	Зарцуулсан Түлш /л	1мот/цаг зарцуулсан	салбаг мян/төг	Тос тосолгоо мян/төг	Их засвар	Дугуй /ш	Техник эзэмшигч
2019	130	564	11867	21	90518	413841	0	0	Э.Загарзүсэм
2020	694	1483	29572	19.9	635627			0	Э.Загарзүсэм
2021	2177							0	Э.Загарзүсэм



Улсын дугаар	
Марк	TEREX №2
Үйлдвэрлэсэн улс	Хятад
Үйлдвэрлэсэн он	1998
Ашиглалтанд орсон он	2001
Зориулалт	Бөрөө буулгагч



Улсын дугаар	0963 өөр
Марк	Land 76
Үйлдвэрлэсэн улс	Япон
Үйлдвэрлэсэн он	2012
Ашиглалтанд орсон он	2012
Зориулалт	Суудал

Он сар	Оны эхний мот/цаг	Ажилсан мот/цаг	Зарцуулсан Түлш /л	1мот/цаг зарцуулсан	салбэг мян/төг	Тос тосолгоо мян/төг	Их засвар	Дугуй /ш	Техник эзэмшигч
2014	4716	594	9510	16				0	Б.Мөнхтуяа
2015	5310	340	5353	16				0	М.Эрдэнэбаяр
2016	5650	615	9906	16	740681	1319998		0	М.Эрдэнэбаяр
2017	6260	523	9410	18.2	3919070	1387999	м/цохсон	0	М.Эрдэнэбаяр
2018	6783	632	10118	16	1079240	2575153		0	М.Эрдэнэбаяр
2019								0	

Он сар	Оны эхний мот/цаг	Ажилсан мот/цаг-км	Зарцуулсан Түлш /л	100км зарцуулсан	салбэг мян/төг	Тос тосолгоо мян/төг	Их засвар	Дугуй /ш	Техник эзэмшигч	
										2014
2015	28727	23880	3085	13			0	0	Д.Мягмар	
2016	52607	27887	3653	13	457040	447272		0	Д.Мягмар	
2017	80494	41421	7927	19.1	2922266	327483		0	4-ш Ц.Мэндсайхан	
2018	121915	26071	5464	21	739150	181034		0	0	Ц.Мэндсайхан
2019	147986	30624	4283	14.7	3093280	217716		4ш	Ц.Мэндсайхан	
2020	178610	41998	4687	11	6243628		ирсн-барав	4ш	Ц.Мэндсайхан	
2021	220608									



Улсын дугаар	
Марк	HYUNDAI 850-LC-9
Үйлдвэрлэсэн улс	Солонгос
Үйлдвэрлэсэн он	2019
Ашиглалтанд орсон он	2019
Зориулалт	Экскаватор



Улсын дугаар	0310 өвө
Марк	УАЗ фургон
Үйлдвэрлэсэн улс	Орос
Үйлдвэрлэсэн он	2014
Ашиглалтанд орсон он	2015
Зориулалт	Суудал

Он сар	Оны эхний мот/цаг	Ажилсан мот/цаг	Зарцуулсан Түлш /л	1мот/цаг зарцуулсан	салбэг мян/төг	Тос тосолгоо мян/төг	Их засвар	Дугуй /ш	Техник эзэмшигч
2020	1320	2190	107990	50	5930335		0	0	С.Баярсайхан
2021	3510								С.Баярсайхан

Он сар	Оны эхний мот/цаг	Ажилсан мот/цаг-км	Зарцуулсан Бензин /л	100км зарцуулсан	салбэг мян/төг	Тос тосолгоо мян/төг	Их засвар	Дугуй /ш	Техник эзэмшигч
2016	13922	12487	1511	12	304500		0		А.Батжаргал
2017	26409	10461	1393	13.3	710454	56992	0		А.Батжаргал
2018	36283	10665	1742	16.3	154630	183288	0	4-ш	А.Батжаргал
2019	46946	15634	1819	12.7	644000	106268	0		А.Батжаргал
2020	2580	15650	4283	15	641000				А.Батжаргал
2021	18230							4-ш	А.Батжаргал





Улсын дугаар	
Марк	ЭКГ-5А
Үйлдвэрлэсэн улс	Орос
Үйлдвэрлэсэн он	1978
Ашиглалтанд орсон он	1999
Зориулалт	Экскаватор

Он сар	Ашигласан квт/цаг	сэлбэг	Тос тосолгоо	Их засвар	Дугуй	Техник эзэмшигч
2014		34055000				Ш.Лхавгадорж
2015		60252000				Ш.Лхавгадорж
2016		99531940	1323816			Ш.Лхавгадорж
2017		75788561	2520718			Ш.Лхавгадорж
2018		45300604	2225183			Ш.Лхавгадорж
2019	129700	39682089	2315409			Ш.Лхавгадорж
2020	171600	42548021		127022200		Ш.Лхавгадорж



Улсын дугаар	0471 өвр
Марк	RHINO
Үйлдвэрлэсэн улс	Солонгос
Үйлдвэрлэсэн он	1997
Ашиглалтанд орсон он	2013
Зориулалт	Ачааны

Он сар	Оны эхний мот/цаг	Ажилсан мот/цаг-км	Зарцуулсан Бензин /л/	100км зарцуулсан	сэлбэг	Тос тосолгоо	Их засвар	Дугуй /ш/	Техник эзэмшигч
2014	130813	14895	2979	20			0		Ш.Лхавгадорж
2015	145708	4500	910	20.2			0	4-ш	Ш.Лхавгадорж
2016	150208	2194	875	39.8	216000	278818	0	0	Ш.Лхавгадорж
2017	152402	1714	724	42		237357	0	0	Б.Батмүрээ
2018	154116	3632	1204	33	68860	404039	0	0	Б.Батмүрээ
2019	157748	1324	820	61	1889300	538705	0	2-ш	Б.Батмүрээ
2020	159072	2000	820	41	784640				Б.Мөнхтуяа



Улсын дугаар	
Марк	HYUNDAI 520-LC
Үйлдвэрлэсэн улс	Солонгос
Үйлдвэрлэсэн он	2014
Ашиглалтанд орсон он	2014
Зориулалт	Экскаватор

Он сар	Оны эхний мот/цаг	Ажилсан мот/цаг	Зарцуулсан Түлш /л/	1мот/цаг зарцуулсан	сэлбэг мян/төг	Тос тосолгоо мян/төг	Их засвар	Дугуй /ш/	Техник эзэмшигч
2015	1148	1614	48615	30.1				0	С.Баярсайхан
2016	2789	1876	59188	31.5	1669544	2113180		0	С.Баярсайхан
2017	4665	1878	75877	40.4	4243941	3263476		0	С.Баярсайхан
2018	6890	2127	64345	30.3	11603768	4037437		0	С.Баярсайхан
2019	9017	1623	54736	33.7	76362965	5268672	мот/зэлж	0	Д.Амарбаясгалан
2020	10640	1296	40161	31	21301479			0	Д.Амарбаясгалан



Улсын дугаар	
Марк	D65E
Үйлдвэрлэсэн улс	Япон
Үйлдвэрлэсэн он	1992
Ашиглалтанд орсон он	2000
Зориулалт	Бульдозер

Он сар	Оны эхний мот/цаг	Ажилсан мот/цаг	Зарцуулсан Түлш /л/	1мот/цаг зарцуулсан	сэлбэг мян/төг	Тос тосолгоо мян/төг	Их засвар	Дугуй /ш/	Техник эзэмшигч
2015	11577	731	8891	12.1	37243880		мот/зэлж	0	О.Амархүү
2016	12308	718	9182	12.7	9387933	1623635		0	О.Амархүү
2017	13026	520	7065	13.6	448112	1134155		0	Э.Орпилбулаг
2018	13563	576	6434	11.2	22434520	729296	мот/зэлж	0	Э.Орпилбулаг
2019	14139	807	9686	12	2065244	1114734		0	Э.Орпилбулаг
2020	14946	797	9360	11.7	905859			0	Э.Орпилбулаг



Улсын дугаар	5425 өвс
Марк	NOVA
Үйлдвэрлэсэн улс	Хятад
Үйлдвэрлэсэн он	2013
Ашиглалтанд орсон он	2013
Зориулалт	Өөрөө буулгагч

Он сар	Оны эхний мот/цаг	Ажилсан мот/цаг	Түлш /л	1мот/цаг зарцуулсан	салбэг мян/төг	Тос тосолгоо мян/төг	Их засвар	Дугуй /ш	Техник эзэмшигч
2013	2631	5297						ө-11-ш	Л.Аюуш
2014	7928	4387	8610	198				0	Л.Аюуш
2015	12315	7401	13084	176.7	2415000			0	Л.Аюуш
2016	19716	6481	12725	196	9618568	2259317	хольц	0	Л.Аюуш
2017	26203	5081	10146	199.7	3334607	1181410	хольц,со	0	Л.Аюуш
2018	31284	5872	12001	204	17597299	744128		8-ш	Л.Аюуш
2019	37156	5044	10128	200.8	9777508	766567	залж-1	0	М.Эрдэнэбаяр
2020	42200	10183	17005	167	19263324		залж-1	4-ш	М.Эрдэнэбаяр



Улсын дугаар	5435 өвс
Марк	NOVA
Үйлдвэрлэсэн улс	Хятад
Үйлдвэрлэсэн он	2013
Ашиглалтанд орсон он	2013
Зориулалт	Өөрөө буулгагч

Он сар	Оны эхний мот/цаг	Ажилсан мот/цаг	Түлш /л	1мот/цаг зарцуулсан	салбэг мян/төг	Тос тосолгоо мян/төг	Их засвар	Дугуй /ш	Техник эзэмшигч
2013	2631	3966км					мотор	ө-11-ш	Ж.Наранбаатар
2014	3966	5621км	10917	194л	850000			0	Ж.Наранбаатар
2015	9587	7358км	13717	186л	2126000			1-ш	Ж.Наранбаатар
2016	16913	7805км	15651	200л	4581497	2346362		2-ш	Ж.Наранбаатар
2017	24716	8299км	3992	207л	7961071	1252470	залж.1	0	Ж.Наранбаатар
2018	28747	750мөт	11999	16л	9068626	1400751		1-ш	Ж.Наранбаатар
2019	447мөт	723мөт	11360	15.8л	28135109	1118685	залж.1	10-ш	Ж.Наранбаатар
2020	1170мөт	918мөт	18741	20.4	7419448		залж.1	0	Ж.Наранбаатар



Улсын дугаар	
Марк	TEREX №2
Үйлдвэрлэсэн улс	Хятад
Үйлдвэрлэсэн он	1998
Ашиглалтанд орсон он	2001
Зориулалт	Өөрөө буулгагч

Он сар	Оны эхний мот/цаг	Ажилсан мот/цаг	Зарцуулсан Түлш /л	1мот/цаг зарцуулсан	салбэг мян/төг	Тос тосолгоо мян/төг	Их засвар	Дугуй /ш	Техник эзэмшигч
2014					29500000			0	
2015	0	627	8160	13	18883000			5-ш	А.Пүрэвсүрэн
2016	627	599	8386	14	3057908	865090		0	А.Пүрэвсүрэн
2017	1226	325	4553	14	853418	837895		0	Э.Амаглан
2018	1551	720	10092	14	5077437	346544		0	М.Амарбаясгалан
2019	2271	441	6390	14.5	7967106	266685		0	М.Амарбаясгалан
2020	2712	75	962	13				0	М.Амарбаясгалан



Улсын дугаар	
Марк	Luogong
Үйлдвэрлэсэн улс	Хятад
Үйлдвэрлэсэн он	2019
Ашиглалтанд орсон он	2019
Зориулалт	Автогрейдер

Он сар	Оны эхний мот/цаг	Ажилсан мот/цаг-км	Зарцуулсан түлш /л	1мот/цаг зарцуулсан	салбэг мян/төг	Тос тосолгоо мян/төг	Их засвар	Дугуй /ш	Техник эзэмшигч
2019	0	223	2125	9.5		354706			Ц.Лхавгадорж
2020	223	962	14068	14.6	1292726				Ц.Лхавгадорж
2021	1185								

“Баянтээг” ХК-ийн 2020 онд төлөвлөсөн ажлын тайлан

Д/Д	Техникийн марк	Хийгдэх ажил	Төлөвлөгө ө /мян.төг/	Гүйцэтгэл /мян.төг/	Тайлбар
<b>ТЕХНИКИЙН ИХ ЗАСВАР</b>					
1	ЭКГ-5А	Хүрдний зам	25,000.0	15,000.0	ком
		Цахилгаан монтаж солих	25,000.0	36,908.3	Ком
		Цах/ хөдөлгүүр засвар	30,000.0	-	хийгдээгүй
		Эргэхийн хөдөлгүүр	35,000.0	-	хийгдээгүй
		5А бусад үйлчилгээ	30,000.0	75,113.9	
2	D-65 бульдозер засвар	Явах анги машмак	40,000.0	-	хийгдээгүй /ком/
		Тулах гатги	9,300.0	-	хийгдээгүй /4ш/
3	TEREX 33-05	Хово мотор, кроп	25,000.0	-	хийгдээгүй /ком/
4	Уурын зуух	Орос тогоо /1мвт/	35,000.0	44,000.0	1
		Хөдөлгүүр /18квт, 15квт/	6,000.0	2,500.0	2
<b>НИЙТ ДҮН</b>			<b>260,300.0</b>	<b>173,522.2</b>	
<b>АЖ АХУЙ, ТЕХНИКИЙН УРСГАЛ ЗАСВАР</b>					
1	HYUNDAI R520 LC-9S	Гидрийн шланг солих	20,000.0	17,213.1	ком
2	HYUNDAI 2900 LC	Гидрийн шланг солих	10,000.0	-	хийгдээгүй /ком/
		Бүрэн ээлж	10,000.0	-	хийгдээгүй
3	Howo 60	Бүрэн ээлж	5,000.0	6,583.6	2ш
		Кроп засвар	2,500.0	400.0	
4	NORTH BENZ	Бүрэн ээлж	10,000.0	6,082.9	2
		Кроп засвар	5,000.0	755.0	2
5	FOTON	Кроп засвар	2,500.0	-	хийгдээгүй
6	Карьер, оффис	Гадна гэрэлтүүлэг	5,000.0	5,000.0	
<b>НИЙТ ДҮН</b>			<b>70,000.0</b>	<b>36,034.6</b>	

---

### **3.4. 2020 оны “Баянтээг” ХК-ний байгаль орчин, нөхөн сэргээлтийн талаар:**

“Баянтээг” ХК нь 2020 онд байгаль орчны нарийвчилсан үнэлгээ менежментийн төлөвлөгөөг “Мэнд шүтээн” ХХК-аар хийлгэн батлуулж, төлөвлөгөөний дагуу байгаль орчин, нөхөн сэргээлтийн арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант онд Байгаль орчин нарийвчилсан үнэлгээ менежментийн төлөвлөгөөний дагуу хийгдсэн ажлууд :

1. Өвөрхангай аймгийн Нарийнтээл суманд орших MV-000367 дугаартай тусгай зөвшөөрөлтэй “Баянтээг”-ийн нүүрсний ордыг ашиглах төслийн байгаль орчны нөлөөлөлийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол хийсэн.
2. Уулын ажлын төлөвлөгөөний дагуу шимт хөрсийг хуулж стандартын дагуу овоолго үүсгэсэн.
3. “Баянтээг” ХК нь дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийн хүрээнд “Таац голын сав газарт” 2 га талбайд ойн зурвас байгуулсан.
4. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу ус, хөрс, ургамал, агаарын мониторингийн ажлыг хуваарийн дагуу тогтмол хийж гүйцэтгэж байна.
5. Усны дүгнэлтийг мэргэжлийн байгууллагаар гаргуулсан.
6. Нарийнтээл сумын Баянтээг багийн Засаг даргатай ус, хог хаягдлын гэрээ байгуулж ажилласан.
7. Хог хаягдлын их цэвэрлэгээг Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу улирал бүр зохион байгуулан ажиллалаа.



1. 2020 онд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Мэнд шүтээн” ХХК-иар 19.9 сая төгрөгөөр хийж гүйцэтгүүлсэн.

Батлав. БОАЖЯ-НЫ ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ  
..... П.ЦОГТСАЙХАН

Шүүмж хийсэн. БОАЖЯ-НЫ ШИНЖЭЭЧ  
.....

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НАРИЙНТЭЭЛ СУМЫН НУТАГТ ОРШИХ МУ-000367  
ДУГААРТАЙ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ “БАЯНТЭЭГ”-ИЙН НҮҮРСНИЙ ОРДЫГ  
АШИГЛАХ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН  
ҮНЭЛГЭЭНИЙ НЭМЭЛТ ТОДОТГОЛЫН ТАЙЛАН

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:  
“МЭНДШҮТЭЭН” ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ ..... Д.ОЮУНЧИМЭГ

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:  
“БАЯНТЭЭГ” ХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ..... О.СУМЬЯАСҮРЭН

УЛААНБААТАР ХОТ  
2020 ОН

---

2. 2020 онд уулын ажлын төлөвлөгөөний дагуу нийт 2,5 га газраас 7,5 мян.м<sup>3</sup> шимт хөрсийг хуулж стандартын дагуу овоолго байгуулсан.



---

3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсанаар “Баянтээг”-ийн нүүрсний уурхай нь дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд жил бүр 2 га талбайд ойн зурвас байгуулахаар төлөвлөгдсөн болно. 2020 онд 2 га ойн зурвасыг Нарийнтээл сумын Засаг даргын Тамгын газартай гэрээ байгуулан Таацын голын экосистемийг сайжруулах зорилгоор ойн зурвас байгуулах ажлыг нутгийн иргэдтэй хамтран зохион байгууллаа. 2 га газрыг ойн зурвас байгуулах ажлын төсөв 19,9 сая төгрөгийг “Баянтээг” ХК-ний байгаль орчны зардлаас гарган санхүүжүүлсэн болно.

**ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ЗУРГАН ТАЙЛАН:**



**Ажил эхлэхээс өмнө талбайн ерөнхий харагдах байдал**



**Хашааг бариж дууссаны дараах харагдах байдал**

4. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу усны шинжилгээг тайлант онд улиралд 2 удаа аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний газраар хийлгэн ажиллаж байна. Усны шинжилгээг карьерийн нуур, гүний худаг 2 цэгээс усны чанарын стандартаас давсан бохирдолгүй гарсан болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу агаарын чанарын шинжилгээг тайлант онд улиралд 2 удаа аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний газраар хийлгэн ажиллаж байна. Агаар дахь Хүхэрлэг хий, азотын давхар исэл, тоосжилтын агууламж агаарын чанарын стандартаас давсан бохирдолгүй гарсан байна

№TL-08-02

УС, ЦАГ УУР, ОРЧНЫ  
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ  
ЛАБОРАТОРИ

Арвайхээр 5-р баг



ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/ : 2020/24  
 Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : БАЯНТЭЭГ-ХХК  
 Дээжийг авсан хүний нэр, албан тушаал : УЦУОШТөв Ш Оюунбилэг  
 Дээжийн тоо, төрөл : Уурхайн карерийн хөрсний сорьц  
 Хүлээн авсан огноо : 2020.09-р сарын 28нд  
 Шинжилсэн огноо : 2020.10-р сарын 3-30 нд

Д/д	Сорьц авсан цэгийн нэр	PH	NH <sub>4</sub>	NO <sub>3</sub>	PO <sub>4</sub>	SO <sub>4</sub>
1	Карерийн гадна нуурын орчим	7.70	8.6	16.2	17.8	75.6
2	Карерийн доторхи ханын хөрс	8.02	33.5	135.6	28.1	200.3
3	Карерийн доторхи овоолсон хөрс	8.05	50.6	70.3	48.3	115.0

Сорьц авсан цэгийн нэр	Cd-	Pb	Hg	Cr	Zn	Cu	Co	Sr
Карерийн гадна нуурын орчим	0.0	11.8	0.0	28.0	120.3	27.0	36.5	252.8
Карерийн доторхи ханын хөрс	0.1	52.0	0.0	60.3	185.6	52.3	40.3	650.3
Карерийн доторхи овоолсон хөрс	0.0	38.4	0.2	55.3	252.3	42.5	35.6	355.6
ЗДХ	3	100	2		300	100	50	800

Шинжилгээ хийсэн:

БОШЛ-ын техникч *Б.Амартүвшин* Б.Амартүвшин

Хяндаж баталгаажуулсан:

БОШЛ-лабораторийн эрхлэгч *Ш.Оюунбилэг* Ш.Оюунбилэг



- 
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу Хөрсний шинжилгээг тайлант онд улиралд 2 удаа аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний газраар хийлгэн ажиллаж байна. Хөрсний шинжилгээг 3 цэг сонгон авч хийсэн бохирдолгүй гарсан.

5. Ус ашиглах дүгнэлтийг Өвөрхангай аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газраар гаргуулан ажиллаж байна.

6. Нарийнтээл сумын ЗДТГ-тай Ус ашиглах гэрээ, Хог хаягдалын гэрээг хийж 2020 онд усны төлбөрт 2,2 сая төгрөг хог хаягдалд 4.2 сая төгрөг төвлөрүүлсэн.

7. Хог хаягдлын их цэвэрлэгээг Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу улирал бүр зохион байгуулан ажилласан. “Баянтээг” багийн төвөөс зүүн зүгт 23 км Шинжэтийн хоолой хүртэлх ойр орчмын хур хог хаягдалийг цэвэрлэн хогын нэгдсэн цэгт хүргэх ажлыг хийж гүйцэтгэсэн




---

### 3.5. Дулаан үйлдвэрлэлийн талаар:

Компанийн дулаан үйлдвэрлэл нь ШГ-1000 квт-ийн төрийн байгууллагууд, аж ахуйн нэгж, айл өрхийг халаадаг нэгдүгээр зуух, өөрийн оффис болон граж, склад, цайны газар зэрэг байгууламжийг халаадаг НР-60Ж маркийн хоёрдугаар зуухаар механик-1, слесарь-1, галч-8 нийт 10 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. 2 зууханд 4 ээлжээр 8/16 цагаар ажилладаг.

2020 онд нийт 19 газар бүхий 14993.71 м<sup>3</sup> халааж байна.

2020 онд дулааны нэгдүгээр зуух нь хуучирч муудан ашиглах боломжгүй болсноор тогоог солих шаардлага үүсэж тендер зарлан 42 сая төгрөгийн өртөгтэй дотоодын үйлдвэрийн “Оргил Турбин Инженеринг” ХХК-ийн үйлдвэрлэсэн ШГ-1000 квт-ийн зуухыг суурилуулан ажиллуулж байна. Тус зуух нь орчин үеийн технилогоор хийгдсэн орчны бохирдол багатай халаалт сайн байгаа хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг хангаж байна.



Зуухны марк ШГ-1000 квт  
Халаах талбай 6800-8600м<sup>2</sup>  
АҮК 80%  
Түлш зарцуулалт 100кг/ц

**Нэгдүгээр зуухны хэрэглээ:**

№	Хэрэглэгчийн нэр	Биет хэмжээ (м.куб)	1м <sup>3</sup> -д ногдох үнэ	Бүгд төлөх үнэ
1	Цэцэрлэг	1108,8	900	997,920
2	Бага сургууль	2417,4	900	2,175,660
3	Эмнэлэг	1152,5	900	1,037,250
4	Багийн захиргаа	411,6	900	370,440
5	Шуудан үйлчилгээ	84	550	46,200
6	ХААН банк	61,6	550	33,880
7	Төрийн банк	53,19	550	29,254
8	Ахмадын өргөө	224	Өөрийн хөрөнгө	
9	Спорт заал	2655	Өөрийн хөрөнгө	
10	12 айлын сууц	928	Өөрийн хөрөнгө	
	8 айлын орон сууц	425,52	Өөрийн хөрөнгө	
	Д.Санжидхорол	309,3	550	170,115
<b>НИЙТ ДҮН</b>		<b>9,890.91</b>		<b>4,860,719</b>

**Хоёрдугаар зуух:**



Зуухны марк НР60Ж  
 Зуухны халаах гадаргуу 65,4 м<sup>2</sup>  
 Зуухны ажлын даралт 6,0 АТА  
 Дулаан гаргах чадал 420000 ккал/цаг  
 Усны тооцоот хэм -95<sup>0</sup>С  
 Зуухны эзэлхүүн 6000м<sup>3</sup>  
 Цагт зарцуулах түлшний хэмжээ 100кг/цаг  
 Зуухны жин 4000кг



**Хоёрдугаар зуухны хэрэглээ:**

№	Хэрэглэгчийн нэр	Биет хэмжээ (м.куб)	1м <sup>3</sup> -д ногдох үнэ	Мөнгөн дүн
1	Контор	1828	Өөрийн хөрөнгө	
2	2 граж	576	Өөрийн хөрөнгө	
3	Гуанз	426	Өөрийн хөрөнгө	
4	Засварын газар	1825	Өөрийн хөрөнгө	
5	Ш.Чимэддолгор	254	550	139,700
6	А.Амаржаргал	105,6	550	58,080
7	Д.Цэрэнбавуу	148,2	550	81,510
<b>НИЙТ ДҮН</b>		<b>5,162.8</b>		<b>279,290</b>

2021 онд дулааны хоёрдугаар зуух нь хуучирч муудан ашиглах боломжгүй олноор тогоог солих шаардлагатай болсон



---

### 3.6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар:

“Баянтээг” ХК-д хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого, хууль тогтоомж, холбогдох журам, стандартыг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах асуудлыг байгууллагын хэмжээнд хариуцан ажиллаж байна. Байгууллагын хамгийн үнэтэй капитал бол боловсон хүчин буюу ажиллах хүч юм. Бид хүмүүсээ хэрхэн аюулгүй ажиллахад сургах, тэдний ажиллах нөхцөл бололцоог хэрхэн хангах зэргээс хамаарч хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл бүрдүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт шаардлагуудын хүрээнд:

- Хувийн хамгаалах хэрэгсэл, ажлын хувцасны олголт, ашиглалтын журам
- Ажлын байран дахь галын аюулгүй байдлыг хангах журам
- ХАБЭА-н ҮОХХСБ комиссын ажиллах журам
- ХАБЭА-н Аюул эрсдэлийг үнэлэх, хяналт тогтоох журам
- Аюулыг илрүүлэх, мэдээлэх, залруулах журмуудыг боловсруулан шинэчлэн батлуулав.

2020 оны 01 дүгээр сарын 13-нд Өвөрхангай аймаг дахь Политехникомын сургуультай хамтран Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, цахилгааны аюулгүй байдал зэрэг сэдвээр нийт ажилчдад сургалт олгосон. Нийт сургалтанд 102 ажилчин хамрагдсанаас байгууллагын сургалтанд 56, гадны сургалтанд 46 ажилчин хамрагдсан байна.



### Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн зардал

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 6.2.-т Аж ахуйн нэгж, байгууллага эрсдэлийн түвшингээс хамааран үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тус тус зарцуулна хэмээн заасны дагуу 2020 оны ХАБЭА-ын зардалд 47653000 төгрөг төсөвлөснөөс 45340390 төгрөгийг зарцуулж, 2021 онд 89593650 төгрөг төлөвлөсөн байна. 2019 онд 56 ажилчин 2020 онд 70, 2021 онд 77-н ажилтантай ажиллахаар төлөвлөсөн ба жилээс жилд өргөжин тэлсээр байна.

Бүх ажилчдыг өвөл, зуны ажлын нормын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслээр бүрэн хангаж, өмсөж хэрэглүүлж хэвшсэн байна.



---

Уул уурхайн хүнд нөхцөлд эрсдэлтэй ажлын байруудад, ажлын аюул эрсдэлийг тооцож түүнд тохирсон эрсдэлийн үнэлгээг хийн аюулгүйн зөвлөгөө зааварчилгааг боловсруулан ажиллаж байна. Ажилтан нэг бүрт болон өөр ажлын байранд шилжин ажиллах, шөнийн ээлжинд хонож ажиллах ажилчдад ХАБЭА-н ажилтан болон ИТА-д аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгөн хяналт тавин ажилладаг. Амралтын өдөр, баяр ёслолын үеэр ИТА-аас хариуцлагатай жижүүрийг томилон эргүүл хяналт хийн ажиллаж байна.

Хүнсний аюулгүй байдлын тухай холбогдох стандартын дагуу байгууллагын хоол үйлдвэрлэл, хүнсний бүтээгдэхүүний тээвэрлэлт, хадгалалтанд хяналт тавин, ажилчдыг эрүүл хоол хүнсээр хангах, хор саармагжуулах бүтээгдэхүүнээр хангах ажлыг зохион байгуулж чацаргана, халуун аарцыг хүйтэн сэрүүний улиралд өдөр бүр уулгаж байна. Ажилчдын аяга таваг, халбага, сэрээг уураар ариутгагч төхөөрөмжөөр ариутган, хоолны чанар, амталгаан дээр хяналт тавин, дээжийг авч хэвшүүлсэн ба тогооч нарыг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан.



“Баянтээг” ХК-ийн ажлын байран дахь covid-19 халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, ажилтны эрүүл мэндийг хамгаалан ажиллах төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Авч хэрэгжүүлж буй ажлуудыг дурьдвал:

Ажилчдыг өглөө ажлын байранд нэвтрэхээс өмнө биеийн халууныг тогтмол хэмжин спиртэн суурьтай гар ариутгагч, нэг удаагийн маскаар ханган хэрэглүүлж хэвшсэн байна. Байгууллагын үйлчилгээний цонх бүрд спиртэн суурьтай гар халдваргүйжүүлэгч уусмал, халуун хэмжигчийг байршуулан тэмдэглэл хөтлөн ажиллаж байна.





